



**“НИЙСЛЭЛ АУДИТ” ХХК**

# **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК**

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр  
тасалбар болгосон санхүүгийн тайлан



# “НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

2016 оны 03 сарын 29 өдөр

Улаанбаатар хот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК –ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бид “ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

#### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь Компанийн захирлуудын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

#### Аудиторын хариуцлага



Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм.

Бид танай санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж Аудитын Олон улсын Стандарт, манай компанийн “Аудит хийх журам”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийг баримтлан хийв. Аудит хийхдээ түүвэрлэсэн анхны баримтаас тайлан хүртэл хөөн шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, задлан шинжлэх, асууж ярилцах

Эдгээр аудитын горимуудыг ашиглав. Бидний хийсэн аудит нь санхүүгийн тайлангийн талаар  
санаалаа илэрхийлэх үндэслэлтэй суурийг бий болгосон гэдэгт итгэлтэй байна.

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний  
өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар  
болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн  
тайлангвааны олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой үзүүлсэн байна.

ЗАХИРАЛ   Т.СУГАРСҮРЭН